

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН  
2022 ОНЫ 06 ДУГААР ХУРАЛДААН**

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 06 дугаар хуралдааныг 11 цаг 20 минутад Нутгийн удирдлагын ордны II давхрын хурлын танхимд хийж, Зөвлөлийн гишүүдийн 61.5 хувийн ирцтэй хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны үйл ажиллагааны тайлан	ШИЙДВЭРЛЭСЭН нь: Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх явцад Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусгаж, тоо баримтыг дахин нягтлан хянаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболд, ахлах мэргэжилтэн Б.Гантөмөр нарт үүрэг болгов.
2	Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн тайлан	ШИЙДВЭРЛЭСЭН нь: Аймгийн Засаг даргын Тамгын газрын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэх явцад Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусган, тоо баримтыг дахин нягтлан хянаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболдод үүрэг болгов.
3	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт	ШИЙДВЭРЛЭСЭН нь: Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн тайланг хэлэлцэх явцад Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусган, тоо баримтыг дахин нягтлан хянаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболдод үүрэг болгов.
4	Аймгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан	ШИЙДВЭРЛЭСЭН нь: Аймгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хэлэлцэх явцад Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусгаж, тоо баримтыг дахин нягтлан, <a href="http://www.new.unelgee.gov.mn">www.new.unelgee.gov.mn</a> Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд оруулан баталгаажуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлэхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Д.Ариунбилэг, мэргэжилтэн Б.Даваасүрэн нарт үүрэг болгов.
5	Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт	ШИЙДВЭРЛЭСЭН нь: Аймгийн Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн 2021 оны биелэлтийг хэлэлцэх явцад Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусгаж, тоо баримтыг дахин нягтлан, <a href="http://www.new.unelgee.gov.mn">www.new.unelgee.gov.mn</a> Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим

		санд оруулан баталгаажуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлэхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Д.Ариунбилэг, ахлах мэргэжилтэн Ц.Оюунчимэг нарт үүрэг болгов.
6	Аймгийн 2021 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайлан	ШИЙДВЭРЛЭСЭН нь: Шилэн дансны тухай хуулийн 2021 оны хэрэгжилтийн тайланг хэлэлцэх явцад Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусгаж, тоо баримтыг дахин нягтлан, <a href="http://www.new.unelgee.gov.mn">www.new.unelgee.gov.mn</a> Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд оруулан баталгаажуулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хугацаанд нь хүргүүлэхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга Д.Ариунбилэг, мэргэжилтэн Б.Даваасүрэн нарт үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР